

БАТЛАВ:
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ
БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА

Б. БУЯННЭМЭХ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
"ЖАВХЛАНТ ОРД" ХХК ЗАХИРАЛ

MENGHEQILU

**"ЖАВХЛАНТ ОРД ХХК-ИЙН
ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ГУРВАНТЭС СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ
"ЗАНГАТ-УУЛЫН ЧУЛУУН НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ"
ТӨСЛИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: МУ-016952
АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5217652

ХЯНАСАН:
ХБОБЗГ-ЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ

/ /

БОЛОВСРУУЛСАН:
"ЖАВХЛАНТ ОРД" ХХК
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

/С.БАТЦЭЦЭГ/

АГУУЛГА

НЭГ.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Ерөнхий мэдээлэл	1
1.2 Төслийн хүчин чадал, ажиллах горим	3

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

5

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОЛШГҮЙ СӨРӨГ НӨӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

5

3.1 Агаарын чанар	5
3.2 Газрын гадарга болон хөрсөн бүрхэвч	6
3.3 Усан орчин	6
3.4 Ургамлан нөмрөг	6
3.5 Амьтны аймаг	6
3.6 Түүх, соёлын дурсгалт зүйл	7

ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

8

4.1 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх , бууруулах арга хэмжээний төлөвлөгөө...	9
4.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	12
4.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	13
4.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	14
4.5 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	15
4.6 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	16
4.7 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	17
4.8 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	18
4.9 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	19
4.10 Байгаль орчны хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	20

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ НИЙТ ТӨСӨВ 21

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн солбицлууд	2
Хүснэгт 2. Шатахууны зарцуулалтаар ялгарах хорт бөдисын хэмжээ	5
Хүснэгт 3 Сөрөг нөлөөллөөс урьчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	9
Хүснэгт 4 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	12
Хүснэгт 5 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	13
Хүснэгт 6 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	14
Хүснэгт 7 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	15
Хүснэгт 8 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	16
Хүснэгт 9 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	17
Хүснэгт 10 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	18
Хүснэгт 11 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	19
Хүснэгт 12 Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	20
Хүснэгт 13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв	21

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Зангат уулын нүүрсний ордын байршил.....	2
Зураг 2. Уулын ажлын механикжуулалтын бүтэц	3
Зураг 3. Баруун зүүн ил уурхайнуудын ерөнхий хэмжээс	4

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Ерөнхий мэдээлэл:

Төслийн нэр:

- “Зангат-Уулын чулуун нүүрсний орд”-ыг ил аргаар ашиглах төсөл

Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагын нэр:

- “Жавхлант орд” ХХК
 - Улсын бүртгэлийн дугаар: 9019058049
 - Регистрийн дугаар: 5217652

Аж ахуй нэгжийн албан ёсны хаяг, утас


- Хаяг: Хан-Уул дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, 26, Их хуралдай бизнес төвийн 1004 тоот
- Утас: 99167457, 86267888, 77111101
- javkhlantord@gmail.com

“Жавхлант-Орд” ХХК нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Зангат уул-1 нэртэй газарт орших 29100.14 га талбайд МУ-016952 дугаарын ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2011 оны 11-р сарын 18-ны өдөр 30 жилийн хугацаагаар авсан.

Зангат уул-1 нэртэй ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай нь Улаанбаатар хотоос 680 км, Даланзадгад хотоос 300 км, Гурвантэс сумын төвөөс 27 км зайд Өмнөговь аймгийн Гурвантэс сумын 2-р багийн нутаг дэвсгэрт оршдог. Тус орд нь К- 47-35, К-47-2 номенклатурт байрладаг.

Зангат-Уулын орд нь зүүн болон баруун гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдэх бөгөөд ордын нийт геологийн нөөц 28.32 сая.тн (ордын баруун хэсгийн геологийн нөөц 18.09 сая.тн, зүүн хэсгийн геологийн нөөц 10.23 сая.тн) уг ордууд хоорондын зай нь 2 км байна.

Үйлдвэрлэлийн ач холбогдол бүхий нүүрсний давхаргуудын зузаан дунджаар 1.25- 13.2 метр бөгөөд баруун ордын хувьд нүүрсний давхарга нь 3.4 км урт сунаж тогтдог бол зүүн орд хувьд 3.7 км урт сунаж тогтдог.



Зураг I. Зангат уулын нүүрсний ордын байршил

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн солбицлууд

№	Уртраг			Өргөрөг		
	градус	минут	секунд	градус	минут	секунд
1	101	17	56.95	43	21	1.31
2	101	14	41	43	21	1.31
3	101	14	41	43	19	46
4	101	11	46	43	19	46
5	101	11	46	43	21	1.31
6	101	7	46	43	21	1.31
7	101	7	46	43	15	28
8	101	15	56	43	15	28
9	101	15	56	43	13	45
10	101	14	9.17	43	13	45
11	101	14	9.17	43	13	1.3
12	101	19	0.68	43	13	1.3
13	101	19	0.68	43	14	1.3
14	101	19	0.68	43	14	55.28
15	101	22	33.66	43	14	55.28
16	101	22	33.66	43	15	48.46
17	101	29	25.25	43	15	48.46
18	101	29	25.25	43	20	33.56
19	101	22	25.89	43	20	33.56
20	101	22	25.89	43	19	46
21	101	17	56.95	43	19	46

Төслийн хүчин чадал, ажиллах горим:

Уурхай нь жилийн 347 хоног тасралтгүй ажиллаж , жилд 1.5 сая.тн нүүрс олборлох хүчин чадалтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Орд ашиглалтын хугацаанд нийт 75.76 сая.м³ хөрс хуулж, 6.4 сая.тн нүүрс олборлоно.

Ордын байгаа район нь ус ихтэй гэж таамаглаж байгаа бөгөөд олборлолтын үед уснаас хамгаалах, ус таталтын технологийг сонгож ажиллаж байна.

Газрын гадаргуу нь бага зэрэг налуу ч олборлолтын явцад ямарваа нэгэн хүндрэл үүсэхгүй. Мөн ордын талбайгаар цас борооны ус, урсдаг жалга байрладаг учир олборлолтын явцад гадаргын уснаас хамгаалах суваг, шуудуу татах шаардлагатай.

Хөрсний эзлэхүүн жин - 2.5 тн/м³

Нүүрсний эзлэхүүн жин (орд баруун хэсэг) - 1.56 тн/м³


Нүүрсний эзлэхүүн жин (орд зүүн хэсэг) - 1.49 тн/м³

Хөрсний чулуулгийн бат бэхийн коэффициент Профессор М.М.Продотьяконовын ангиллаар $\Gamma=3-7$ байна.

Зангат-Уулып ордын баруун хэсэг нь 45-70 градусын уналтай газрын гадаргуугаас 400 метр бол зүүн хэсэг нь 37-50 градусын уналтай газрын гадаргуугаас 270 метрийн гүнд тус тус сунаж тогтдог.

Тус ордын нүүрсний биетийн геологийн тогтцын үзүүлэлтүүдээс хамааруулан ордыг гадаад овоолготой авто тээвэртэй ашиглалтын системээр ашиглаж байна.


“Баян-Толгой” ил уурхайн уулын ажлын механикжуулалтын бүтцийн схемийг дараах зурагт үзүүлэв.



Зураг 2. Уулын ажлын механикжуулалтын бүтэц

Бид 2023 онд **22255 м³** шимт хөрс, **2,221,513 м³** хөрс хуулалтын ажил гүйцэтгэж, **309,851 м³** нүүрс олборлосон.

Уг уурхайн олборлолтын улмаас одоогийн байдаар нийт **165 га** тайлбай нөлөөлөлд өртсөн байна.



Зураг 3. Баруун зүүн ил уурхайнуудын ерөнхий хэмжээс

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэр болох Өмнөговь аймгийн Гурвантэс сум нь байгалийн бүс бүслүүрийн хувьд ДТД 1140-2769 метрт өргөгдсөн уулс, говь тал, хөндий хоолойнууд бүхий цөлөрхөг бүсэд оршино.

Уур амьсгал эрс тэс, ширүүн, хуурай, дулаанаас хүйтэвтэр хосолсон шинжтэй, өвөлдөө хүйтэвтэр зун нь аагим халуун, хавартаа салхи шуурга ихтэй.

Жилийн дундаж температур 4,0°C -4,6°C, салхины дундаж хурд 3,6 м/с байна. Хур тунадасны жилийн хэмжээ 100 мм-ээс хэтэрдэггүй.

Хүн амын нягтшил бага (1км-т 0.2 хүн), 5291 хүн амтай, 27900 км/кв газар нутагтай. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн 5 багтай. Ерөнхий боловсролын 12 жилийн сургууль, эрүүл мэндийн төв, цэцэрлэг, соёлын төв гэх мэт төр төсвийн байгууллага, худалдаа үйлчилгээний чиглэлийн болон уул уурхайн ААНБ-ууд үйл ажиллагаа явуулдаг. 2023 оны жилийн эцсийн байдлаар 173603 толгой мал тоологдсон. 649 малчин өрхтэй.

Уурхай нь төв суурин газруудтай шороон замаар холбогддог. Нүүрсний гадаад тээвэрт хатуу хучилттай хүнд даацын 18 км зам тавьж эхэлсэн.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

1.1.1. Агаарын чанар

Агаарын бохирдолт гэдэг нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад үүссэн хорт хий, тоос болон бусад бодисын нөлөөгөөр агаарын чанарын хүлцэх хэмжээнд гарсан өөрчлөлт юм.

Зангат уулын чулуун нүүрсний уурхайн технологийн үйл ажиллагааны явцад агаар орчныг бохирдуулж байгаа гол сөрөг нөлөөлөл нь хөрс хуулалт, нүүрс тээвэрлэлт, ачих буулгах процесс. өрөмдлөг тэсэлгээнээс гарах тоосжилт, дуу чимээ юм, Мөн тээврийн хэрэгслийн дотоод шаталтаас үүсэх хорт хий, утаа ялгарна.

Тоосжилт нь гадаад овоолго болон эвдэрсэн газраас ихээр үүсэх ба 1тн шорооноос 50 гр тоосонцор гардаг.

Хүснэгт 2. Шатахууны зарцуулалтаар ялгарах хорт бодисын хэмжээ

№	Хорт бодис	Шатахууны төрөл	
		Бензин г/кг	Дизель түлш
1	Нүүрстөрөгчийн давхар исэл	225	20-30
2	Азотын давхар исэл	55	20-40
3	Нүүрстөрөгч	20	4-10
4	Хүхэрлэг хий	1.5-2.02	10-30
5	Хөө тортог	1-1.5	3-5
6	Хартугалга	0.5-0.85	-
7	Бенз-а-пирсен	0.23	0.31
8	Альдегид	0.8-1.0	0.8-1.0

3.2. Газрын гадарга болон хөрсөн бүрхэвч

Уурхайн ашиглалтын хугацаанд байгалийн ландшафтын унаган төрх алдагдаж 5000 м урттай, 3000 м өргөнтэй, 60 м гүнтэй хоосон орон зай үүснэ.

2023 оны байдлаар уурхайн ашиглалтын үйл ажиллагааны улмаас 55.8 га талбай элэгдэл, эвдрэлд өртсөн бөгөөд 2024 онд уурхайн олборлолтонд 164.3 га талбай өртөнө.

Хөрс хуулалтаас гарсан шимт хөрс удаан хадгалах явцад шимт, шимэрхэг чанараа алдана. Мөн хөрс хуулалт, нүүрс олборлолтын (тэсэлгээ, малталт, ачилт зэрэг) үйл ажиллагааны явцад нарийн шороо, нунтаг нүүрс их дэгдэнэ.

Ялангуяа хүнд оврын техникээр шимт давхаргын шороо, гадаад овоолгын шороо ачих, тээвэрлэх, буулгах ойрын зайны олон удаагийн тээвэрлэлтийн үед хөрс нь их халцайн нунтгарснаас орчны хөрс, ургамал нь нарийн шороо, тоосонд дарагдаж доройтолд оруулна. Техник тоног тохөөрөмжийн засвар үйлчилгээнээс гарсан ШТМ-алдагдсанаас хөрс хүнд металаар бохирдож болзошгүй.

3.3. Усан орчин

Зангат уул ордын орчимд байнгын урсгалтай урсгал ус байхгүй учраас гадаргын усанд учирч болзошгүй сөрөг нөлөөлөл үндсэндээ байхгүй.

Харин уурхайн шүүрлийн усыг зайлууснаас усны түвшин буурна.

Төслийн үйл ажиллагааны үед ахуйн бохир ус, хатуу хог хаягдал, нефтийн бүтээгдэхүүн, шатах тослох материал ил задгай хаяж алдагдсанаас хур борооны усаар утаагдан гүний усны чанарт шууд сөргөөр нөлөөлж болзошгүй.

3.4. Ургамлан нөмрөг

Зангат уул орд газрын ашиглалтад өртөх талбайн ургамлан нөмрөг 230 га талбай арчигдах, дарагдах байдлаар сүйтгэгдэнэ. Тоосжилтоос ургамлын фотосинтез зогсоно.

Уурхайн объектуудаас алслах тутам нөлөөллийн эрчим буурч, ургамалжилт болон ургамлын зүйлүүд нөлөөлөлд автахгүй болно. Иймд уурхайн үйл ажиллагаанд ургамал хамгааллын арга хэмжээг хэрхэн авч хэрэгжүүлснээс нөлөөллийн эрчим шууд хамаарна.

3.5. Амьтны аймаг

Зангат уул орд газрын ашиглалтаас дараах байдлаар амьтны аймагт нөлөөлөл үзүүлэхээр байна. Үүнд:

- Уурхайн хөрс хуулалт шавьжнуудын амьдрах орчинд нөлөөлж тоо толгой нь багасах,

- Уурхайн үйл ажиллагааны улмаас (тэсрэлт, дэлбэрэлт, чимээ шуугиан, гэрэл, машин техникийн үйл ажиллагаа) ашиглалтын талбайгаас шувуу, урт хөлийн амьтад дайжиж үгүй болох,

Түүнчлэн төслийн дэд бүтэцтэй холбоотойгоор амьтдын амьдрах орчин алдагдах,

Техноген болон хүний өөрчилсөн орчинтой холбоотойгоор зарим нэг шинэ зүйлийн шавьжнуудын тоо толгой өсч болох,

- Биологийн төрөл зүйлийн нэгийг нөгөөгөөр орлуулж болдоггүй, бие биенийхээ хэвийн амьдралаас шууд шалтгаалан экологийн тэнцэлд зохицон байдаг гинжин хэлхээ

тасрахаар экологийн тэнцэл алдагдаж тэнд амьдралгүй болдог зүй тогтол үүсэх,

- Уурхайн ухааш, нүх, суваг шуудуунд мал, амьтан унах, ялангуяа салхи шуурганд уруудсан мал уурхайн ухашинд олноороо унаж сүйдэх,

- Мал сүрэг, ан амьтдын бэлчээр хорогдох,

- Шинээр ирж ажиллаж суурьших хүмүүс зэрлэг ан амьтдыг хууль бусаар агнаж болзошгүй.

3.6. Түүх, соёлын дурсгалт зүйлс

“Жавхлант орд” ХХК нь Монгол Улсын “Соёлын Өвийг хамгаалах тухай” хуулийн 6 дугаар бүлгийн 17 дугаар зүйлийн 10-т заасны дагуу ашиглалтын талбайд археологийн хайгуул судалгаа хийлгэсэн. Хайгуул судалгааны явцад нийт 27 дурсгалыг илрүүлж бүртгэн тэмдэглэн, баримтжуулсан.

Дурсгалуудыг ангилвал хүрэл зэвсгийн үед холбогдох хэлбэрт булш 9, хиргисүүр 2, тахилын зориулалттай чулуун байгууламж 4, он цаг тодорхой бус зууван дөрвөлжин булш 4, дугуй хэлбэрийн булш 7, ХУ11-Х1Х зууны үед хамаарах хөшөө чулуу 2 эдгээр нь уулын налуу энгэрт болон тэгш дэвсэг газар хэд хэдээрээ болон ганц нэгээрээ оршино.

ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны хүчин зүйл, түүнд үзүүлэх нөлөөлөл, хэрэгжүүлэх хугацаа мөн төслийн зүгээс сөрөг нөлөөллийг бууруулах, түүнчлэн хууль эрх зүйд нийцсэн арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг урьдчилан тооцоолон гаргасан.

2024 онд “Зангат уул” төслийн ажлыг үргэлжлүүлэх, холбогдох дэд бүтцийн бүтээн байгуулалтыг ажлыг гүйцэтгэх (зам барих) гэх мэт үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх арга хэмжээг дараах байдлаар төлөвлөв.

Төлөвлөгөөт онд байгаль орчны хамгааллын чиглэлээр дараахь гол зорилтуудыг дэвшүүлсэн болно. Үүнд:

- ❖ Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх байгаль орчны бүрдэл хэсгүүдэд нөлөөлөх сөрөг нөлөөллийг аль болох бага хэмжээнд байхад анхаарах, тэдгээр нөлөөллүүдийг бууруулах, хөрсний үржил шимийг алдагдуулахгүйгээр хадгалах.
- ❖ Уурхайн үйл ажиллагаанд Монгол улсын хууль, тогтоомж, стандартыг мөрдөн ажиллах.
- ❖ Олборлолт болон тоосжилтыг байгаль орчинд сөрөг нөлөө багатайгаар явуулах талаар хатуу анхаарах
- ❖ Баясах багийн малчдаас бүрдсэн байгаль орчны хамгаалах хяналтын багийг бүрдүүлэн олон нийтийн оролцоог хангах
- ❖ Нөхөн сэргээлт дүйцүүлэн хамгааллын ажлыг оновчтой, чанартай гүйцэтгэх
- ❖ Орчны хяналт шинжилгээг тогтмол системтэй хэрэгжүүлж, байгаль орчны төлөв байдлын өөрчлөлтөд шинжлэх ухааны үндэслэлтэй анализ дүгнэлт хийх

4.1 . СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 3

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян/төг	Тоо хэмжээ	Нийт зэрдал, мян/төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг	
1	2	3	4	5	6	7	8	9	
Агаарын чанарт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ төлөвлөгөө									
1.	Тоосжилт, агаарын чанарын өөрчлөлт	Техникийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилтийг бууруулах зорилгоор замын засвар үйлчилгээ, усалгааг тогтмол хийх	Тээврийн болон технологийн зам	Рейсийн тоо	Гэрээний нөхцлөөр	Үйл ажиллагтай уялдуулан	Дотоод зардалд	Жилийн турш	Агаарын тухай хууль Агаарын бохирдлын хууль MNS 6617-2-3- 16:1998
2.		Агаарын тоосонцорын хэмжилтийг тогтмол хийх	Төслийн талбайн орчимд	Хуваарийн дагуу	ОХШХ тусгагдсан	Жилийн турш	ОХШХ тусгагдсан	Жилийн турш	
3.		Агаарын чанарын шинжилгээг итгэмжлэгдсэн лабораторит хийлгэнэ.		удаа				2	
Гадаргын ба газрын доорхи усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ төлөвлөгөө									
4.	Уурхайн ус зайлуулагтаас	Гүний худагт усны тоолуур суурилуулан баталгаажуулах	Уурхайн унд ахуйн худаг			1 удаа	Дотоод зардалд	1 -р сард	Усны тухай хууль, MNS 8900:2005 стандарт
5.	ордын ойр орчмын бүс нутагт газар доорхи усны түвшин буурах	Төслийн нөлөөлөлд өртөх талбайн мониторингийн цэгүүдэд усны түвшин хэмжилтийг сар бүр хийх , хэмжигч багаж авах	Ил уурхайн үйл ажиллагааны хүрээнд	Хуваарийн дагуу	1000.0	4-6 удаа	5,400.0	Сар, улирал бүр	
6.	Усны чанарт үзүүлэх нөлөөлөл	Мониторингийн цэгүүдээс усны чанарын шинжилгээг бүх үзүүлэлтээр авч шинжлүүлэх	Нөлөөллийн бүс	тоо	ОХШХ-н зардалд	4 удаа	ОХШХ-н зардалд	Улирал бүр	Усны тухай” хууль, Ус бохирдуулсны төлбөрийн журам. Усны нөөцийг бохирдлоос хамгаалах дүрэм. БО болои ЭМ-н сайд нарын хамтарсан тушаал 167/335/A171
7.		Унд ахуйн худгийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлж, худгийн орчны цэвэрлэгээг тогтмол хийх	Унд ахуйн худаг	удаа	Дотоод зардалд	12	Дотоод зардалд	Сар бүр	
8.	Усны хэрэглээ	Ус ашиглах дүгнэлт, зөвшөөрлийг холбогдох байгууллагуудаас авч, гэрээ байгуулах, усны нөөц ашигласны төлбөр хураамжийг сар бүр орон нутгийн төсөвт төвлөрүүлэх	Гүний худаг, шүүрлийн ус	м ³	Дүгнэлтээр үндэслэн	Тоолуурын заалтаар үндэслэн		Сар бүрийн 25-ны дотор	
9.	Ауйн бохир ус	Ажилчдын хотхоны ахуйн хэрэглээнээс гарах бохир усыг байгальд халгүй зайлуулах, цэвэрлэх байгууламжид нийлүүлэх, гэрээ хийх, ус бохирдуулсны төлбөр болон, бохир ус цэвэршүүлсний төлбөрийг төлөх	Ажилчдын ахуйн хэрэгцээнд ашиглах усны хэмжээгээр	тонн	8000.0 Гэрээний үнийн дүнгээр	Бохир усны хэмжээгээр	Хог хаягдлын менежмент төлөвлөгөөний зардалд тусгана	Жилийн турш	

Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ төлөвлөгөө

11.	Хөрс элэгдэх, эвдрэх	Уурхайн үйл ажиллагаа болон бусад газар шорооны ажлаар хөндөгдөх талбайн өнгөн хөрсийг тусгайлан хуулж, шимт хөрсний овоолгын стандартад нийцүүлэн хэлбэршүүлж хадгалах, бүртгэл хөтлөх, хаягжуулах	Уурхайлалтад өртөх талбайн хөрс	м ³	Дотоод зардалд	Үйл ажиллагтай уялдуулан	Дотоод зардалд	Жилийн турш	Газрын тухай хууль, Цөлжилтөөс сэргийлэх....
12.		Уурхайн орчимд болон орон нутгийн замын хөдөлгөөнд оролцохдоо олон салаа зам гаргахгүйгээр нэг чиглэлийн замаар зорчих, машин техникийн хөдөлгөөнд хяналт тавих	Төслийн талбай орон нутгийн зам	га	Дотоод зардалд	Жилийн турш	Дотоод зардалд	Жилийн турш	
13.	Хөрс бохирдол	Шатах тослох материалын асгаралтаас урьдчилан сэргийлэх, болзошгүй асгаралтаар бохирдсон хөрсийг цэвэршүүлж, саармагжуулах үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах	Төслийн талбай	м ³	Хог хаягдлын менежмент төлөвлөгөөний зардалд	Жилийн турш	Хог хаягдлын менежмент төлөвлөгөөний зардалд	Жилийн турш	Газрын тухай хууль, Хог хаягдлын тухай хууль

Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ төлөвлөгөө

14.	Газрын хэвлий эвдрэх	Хөрс хуулалт, олборлолтын ажлыг уулын ажлын технологийн дагуу зохион байгуулж, уурхайн ухалт, малталт, өрөмдлөг тэсэлгээний ажлын үе шат бүрт инженерийн хяналтыг хэрэгжүүлж, экологи, эдийн засгийн гарз хохирол өртөг зардал хамгийн бага байлгахад анхаарч ажиллах.	Уурхайлалтад өртөх талбай	м ³	Дотоод зардалд	Жилийн турш	Дотоод зардалд	Жилийн турш	Газрын тухай хууль АМТХ
15.	Газар ашиглалт	Газар ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, эдэлбэр газрын нэгж талбар бүрийн үнэлгээгээр газрын төлбөрийг бүрэн төлөх	Ашиглаж буй 35 нэгж талбар	Нэгж талбар	Нэгж талбар тус бүрийн үнэлгээгээр	35	Дотоод зардалд	3-р улиралд багтааж	Газрын тухай хууль

Ургамлан нөмрөгөд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ төлөвлөгөө									
16.	Ил уурхайн ахилт болон овоолгод ургамлан бүрхэвч дарагдаж устгах	Хөндөгдөж буй талбайн ургамлын бүртгэл хөтлөх, ховор, нэн ховор ургамлыг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авах	Уурхайлалтад өртөх талбай	Ширхэг	Нөхөн сэргээлтийн зардалд	Хөндөгдөх талбайд тохиолдох төрөл зүйлийн тоогоор	Нөхөн сэргээлтийн зардалд	Үйл ажиллагтай уялдуулан	Байгалийн ургамалын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, БОНБУ-ний тухай хуулиуд
17.		Нөлөөллийн бүсийн экосистем дэх ургамлын бичиглэл, мониторинг, тооллогын ажлыг ОХШХ-т тусган хэрэгжүүлэх	Нөлөөллийн бүс	га	ОХШХ зардалд		ОХШХ зардалд	2-3 улиралд	
Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ төлөвлөгөө									
18.	Төслийн болон ойр орчны нутаг дэвсгэр дэх амьтны аймгийн нутагшил хумигдах	Төслийн талбайд хийгдсэн биологийн олон янз байдлын судалгаанд үндэслэн төслийн талбай болон нөлөөллийн бүсэд амьтны мониторинг судалгаа хийж, амьдрах орчны доройтлоос урьдчилан сэргийлэх ажил, биотехникийн арга хэмжээ зохион байгуулна.	Нөлөөллийн бүс	тоо	1000.0	3	3000.0	3, 11, 12 —р сард	Амьтны тухай хууль 6.1.7 үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан хөнөөгдөхөөс сэргийлэх
19.	Амьтны тоо толгой цөөрөх	Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэр, говь цөлийн экосистемийн унаган амьтдын төрөл зүйлийг уурхайн ажилчид, орон нутгийн хүүхэд залууст сурталчилан таниулах өдөрлөг, сургалт танин мэдэхүйн арга хэмжээг Говь гурван сайханы БЦГ-ын хамгаалалтын захиргаа болон орон нутгийн боловсролын байгууллага сургууль цэцэрлэгүүдтэй хамтран зохион байгуулна.		Тоо	1000.0	2	2000.0	5, 10-р сард	
Нийт							10,400.0		

4.2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 4

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян/төг	Нийт зардал, мян/төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Техникний нөхөн сэргээлт	Шимт хөрсний овоолгын хэлбэржүүлэлт хийж ургамалжуулахад бэлтгэх	га	1			4-р сард	•MNS 5915:2008, ■ MNS 5917:2008, • MNS17.5.1.19-92,- Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал (2015 оны А-138)
2.	Биологийн нөхөн сэргээлт	Шимт хөрсний овоолгыг ургамалжуулах	га	1	10,000.0	10,000.0	5, 10 -р сард	•\1\8 5915:2008, • MNS 5917:2008, • M\8 5918:2008, • MNS 17.5.1.19-92, •Уулуурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал (2015 оны А-138)
Нийт						10,000.0		

4.3. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 5

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян/төг	Нийт зардал, мян/төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний санал авах	Орон нутгийн иргэд болон захиргааны саналыг харгалзан төлөвлөгөө боловсруулна.	Өмнөговь аймгийн Гурвантэс сум	-	500.0	500.0	1 -р улиралд	БОНБУ-ний тухай хууль
2	Амьтны төрөл зүйлийг хамгаалахад чиглэсэн ажил	Ан амьтанд зориулсан автомат ажиллагаатай уст цэг байгуулах	Баясах багын нутагт	1	10,000.0	10,000.0	1,2-р улиралд	БОМТөлөвлөгөө, нутгийн иргэдийн хүсэлт
3	Тэрбум мод үндэсний хөдөлгөөн	Гурвантэс суманд 2030 он хүртэл нийт 1,5 сая мод тарихаас 2024 онд 3000	Өмнөговь аймгийн Гурвантэс сум.	3000		10,000.0	3,4 дугаар улиралд	
	Нийт					20,000.0		

4.4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 6

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.								
	Нийт							

Өмнөх онуудын үйл ажиллагааны хүрээнд шаардлагатай нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор бүрэн хийгдсэн тул энэ онд нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгдөөгүй.

4.5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 7

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6		8
1.	Палеонтологийн дурсгал	Хайгуул судалгааны талбай, Уурхайн тэлэлтэнд өртөх талбайд Археологи, Палеонтологийн олдвор илэрвэл холбогдох төрийн байгууллагад мэдэгдэж авран хамгаалах арга хэмжээ зохион байгуулна.			Зардал тооцох боломжгүй	Зардал тооцох боломжгүй	Жилийн турш	МУ-ын Соёлын өвийн тухай хуулийн 27.8, 27.9 БСШУ сайд 222 дугаар тушаал
	Нийт					-		

“Жавхлант орд” ХХК нь 2016 онд “Соёлын Өвийг хамгаалах тухай” хуулийн дагуу ашиглалтын талбайд археологийн хайгуул судалгаа хийлгэсэн. Хайгуул судалгааны явцад нийт 27 дурсгалыг илрүүлж бүртгэн тэмдэглэн, баримтжуулалт хийсэн.

Дурсгалуудыг ангилвал хүрэл зэвсгийн үед холбогдох хэлбэрт булш 9, хиргисүүр 2, тахилын зориулалттай чулуун байгууламж 4, он цаг тодорхой бус зууван дорвөлжин буши 4, дугуй хэлбэрийн булш 7, Х^УП-ХТХ зууны үед хамаарах хөшөө чулуу 2 эдгээр нь уулын налуу энгэрт болон тэгш дэвсэг газар хэд хэдээрээ болон ганц нэгээрээ орших бөгөөд архелогийн судалгаа, усгаатан зүй судалгаа болон дурсгалуудыг авран хамгаалах ажил хийгдсэн болно. 2024 онд эдгээр дурсгалуудаас уурхайн нөлөөлөлд өртөхгүй.

4.6. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн үйл ажиллагаанд өрөмдлөг, тэсэлгээний бодис, материал ашиглах ба химийн гаралтай шатахуун болон шатах, тослох материал ашиглана. Иймд Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2009 оны 02 сарын 03-ны өдрийн 28/40/29 дүгээр хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулиудыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллана.

2024 онд Жавхланта орд ХХК нь уулын ажлын төлөвлөгөөний дагуу тэсэлгээ өрөмлөгийн ажлыг тусгай зөвшөөрөлтэй туслан гүйцэтгэгч компаниар гүйцэтгүүлнэ.

Хүснэгт 8

	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян/төг	Нийт зардал, мян/төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого	ХАБЭА-н дүрэм журмыг сахин ажиллах, нийт ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах	Бүх ажилчид			6,100.0	Жилдээ	Хөдөлмөр хамгаалалын тухай хууль
2	Шатах тослох материалын асгаралт	Шатах тослох материалын болон хаягдлыг түр хадгалах цэгийг хөрс бохирдохоос хамгаалж бэлтгэх	Төслийн талбай дахь ШТС, засварын газар, цахилгаан үүсгүүрийн байр, хаягдал тос хадгалах цэг	2	1000.0	1000.0	Жилдээ	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль,
	Нийт					7,100.0		

4.7. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 9

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян/төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян/төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1.	Ахуйн	Уурхайн ажилчид, гэрээт тээврийн компанийн ажилчдад хог хаягдлын ангилан ялгалтын ач холбогдлын талаар сургалт	Кемп		Дотоод зардалд	4	Дотоод зардалд	Улирал бүр	Байгаль орчны тухай багц хууль, Хог хаягдлын тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, холбогдохдүрэм, журам, стандартыг мөрдлөгө болгон ажиллана.
2.		Уурхайн ажилчид, тээврийн компаний ажилчдыг хамарсан нийтийн цэвэрлэгээний ажлыг тогтмол зохион байгуулах			Дотоод зардалд	Хуваарийн дагуу	Дотоод зардалд	Жилийн турш	
3.		Хатуу, шингэн хог хаягдлыг зайлуулах, устгах ажилд “Шугшаа -Уул” ОНӨААТҮГ -тай гэрээ байгуулан		Тн/м ³	Гэрээний үнийн дүнгээр		Нийлүүлсэн хог хаягдлын хэмжээгээр	1-р сард	
4.		Дахин ашиглах, дахин боловсруулах хаягдлыг хоёрдогч түүхий эд авах газарт нийлүүлэх, хог хаягдлыг дахин ашиглах шинэлэг санаа нэвтрүүлэх арга хэмжээ зохиох			Дотоод зардалд	1	Дотоод зардалд	2-р улиралд	
5.	Үйлдвэрийн	Хаягдал дугуй, машин техникийн эд анги, хаягдал төмөр, зэргийг ангилж цуглуулах, аюулгүй хадгалах арга хэмжээг холбогдох хууль стандартын шаардлагад нийцүүлэх	Засварын газрууд		1000.0	1 удаа	1000.0	3-р улиралд	
6.		Хаягдал тос хадгалах цэгийг стандартад нийцсэн байгууламж хэлбэрээр тохижуулах, тос цуглуулах савны багтаамжийг нэмэгдүүлэх			Дотоод зардалд	1	Дотоод зардалд	2-р улиралд	
7.		“Алтан-Оршихуй”ХХК-тай хаягдал тог нийлүүлэх гэрээний дагуу хамтран ажиллах. Хаягдал аккумулятор, тос маслын сав, торхыг устгах дахин боловсруулах эрх бүхий мэргэжлийн байгууллагад нийлүүлэх		тн	Гэрээний үнийн дүнгээр		Нийлүүлсэн хог хаягдлын хэмжээгээр	Жилд 2	
8.	Аюултай	Эмнэлгийн болон бусад аюултай хог хаягдлыг стандарт шаардлагын дагуу зөвшөөрөлтэй байгууллагад нийлүүлж устгуулах	Төслийн талбайд	кг	Гэрээний үнийн дүнгээр	4	Нийлүүлсэн хог хаягдлын хэмжээгээр	180 хоног тутамд	
Нийт							3,200.0		

4.8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 10

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, мян/төг	Нийт зардал,төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	2	3	4	5	6	7	8	
1.	Агаарын чанар	Төслийн талбай дахь мониторингийн цэгүүдэд	2,4-р улиралд	2	230.0	460.0		MNS 17-2-5-12-2021, MNS17-2-5-11-2021 MNS 5002:2000, CA3 AO7-2016
2.	Усны шинжилгээ	Гүний худаг, шүүрлийн ус, нөлөөллийн бүсийн худаг, нөлөөллийн бүсийн булаг шанд,	Улирал бүр	4	800.0	3,200.0		MNS 1097:1970, MNS 6271:2011, MNS 18010523:2001, MNS 180 9297:2005, MNS 180 6059:2005, MNS 180 8288:1999,
		Ахуйн бохир ус	Улирал бүр	4	200.0	800.0		MNS 180 5815:2001, MNS 180 10523:2001, MNS 180 11923:2001, MNS 180 9297:2005, MNS 5668:2006
3.	Хөрсний шинжилгээ	Төслийн талбай дахь мониторингийн цэгүүдэд	Жилд 2 удаа	2	1,500.0	3,000.0		MNS 180 11466:2007, MNS 6824:2020, MNS 3310:1991, MNS 180 10390:2001
4.	Ургамлын мониторинг	Төслийн талбай дахь мониторингийн цэгүүд, нөлөөллийн бүсэд	2,3 —р улиралд	6	50.0	300.0		
5.	Амьтны мониторинг	Төслийн талбай дахь мониторингийн нөлөөллийн бүсэд	Улирал бүр	4	50.0	200.0		
Нийт						7,960.0		

Дээж, сорьцыг итгэмжлэгдсэн лабораториудад батлагдсан арга зүй, стандартыг дагуу шинжлүүлнэ. Хяналт шинжилгээний үр дүнг хянах үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагууд, орон нутгийн иргэдийн хөндлөнгийн хяналтын доор гүйцэтгүүлэх зэргээр оролцогч талуудыг хяналтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.

**4.9. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 11

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв/ мян.төг	Хэрэгжүүлэх хуваарь												Хариуцсан албан тушаалтан	Тайлбар	
			2024 он														
			1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12			
1	2	3												4	5		
1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, биелэлтийг хугацаанд нь тайлагнах	250.0														БОМ	Нөлөөлийн бүсийн иргэд төрийн байгууллагад
2	ОХШХ, нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгааллын ажилд гэрээт туслан гүйцэтгэгч компаниудын оролцоог нэмэгдүүлэх		▶		▶	▶	▶	▶	▶	▶	▶	▶	▶	▶		БОМ	Гэрээт болон туслан гүйцэтгэгч компаниудын ажилчидийг хамруулах
3	ХОБОМ /хамтын оролцоотой байгаль орчны менежмент/-ын зарчмыг баримталж, нутгийн иргэдийн хяналт оролцоог нэмэгдүүлэх	500.0	▶		▶	▶	▶	▶	▶	▶	▶	▶	▶	▶		БОМ	Нөлөөлийн бүсийн иргэд
4	БОМТ-ний зорилтуудыг цаг улиралын онцлогт тохируулан каледарчилсан дэд төлөвлөгөөнд хувааж хэрэгжүүлэх		▶													БОМ	
5	Байгалийн баялгийг ашиглахтай холбоотой, дүгнэлт, зөвшөөрөл, гэрээ бичиг баримтын бүрдлийг хангах	250.0	▶	▶										▶		БОМ	Эрх бүхий байгууллагаас
6	Дэлхийн усны өдөр /3-р сарын 22/-ийг тохиолдуулан Гурвантэс ЗДТГ-тай хамтран сумын нутагт ус ашиглагч иргэн, аж ахуй нэгж байгууллага, мэргэжилтнүүдийн дунд “Ус хэмнэх дэвшилтэт арга технологи” сэдэвт туршлага солилцох уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах	2,800.0															
7	Олон улсын биологийн төрөл зүйлийн өдөр /5-р сарын 22/-ийг тохирлдуулан сургуулийн сурагчдын дунд “Танья- хайрлая” сэдэвт ан амьтны төрөл зүйлийн тухай танин мэдэхүйн видео эвлүүлэгийн уралдаан зохион байгуулах.	1,000.0															
8	Озоны давхаргыг хамгаалах өдөр /9-р сарын 16/-ийг тохиолдуулан “Урамшуулалт уралдаант” хог цэвэрлэгээ зохион байгуулах	2,000.0															
	Нийт	6,800.0															

**4.10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ
НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 12

	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, мян/төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Уурхай орчимд амьдардаг малчид болон багийн иргэд	Бичгээр болон амаар	БОМТ хэрэгжилт	2,4-р улирал	1,000.0	Орон нутаг харицсан ажилтан, байгаль орчны мэргэжилтэн	Гурвантэс сум, Уурхай
2	Төрийн байгууллага	Бичгээр болон амаар	БОМТ хэрэгжилт	Хагас бүтэн жилээр			
	Нийт				1000.0		

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ НИЙТ ТӨСӨВ

Хүснэгт 13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв

№	Зардлын ангилал	БОННУ-ээр батлагдсан 5 жилийн хугацаанд зарцуулах нийт төсөв мян. төг	Үүнээс 2024 онд зарцуулах төсөв мян.төг
1	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	52,000.0	10,400.0
2	Техникийн нөхөн сэргээлт	3,554,676.0	-
3	Биологийн нөхөн сэргээлт		10,000.0
4	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	100,000.0	20,000.0
5	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ	-	-
6	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-	-
7	Эрсдлийн менежментийн төлөвлөгөө	35,500.0	7,100.0
8	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	16,000.0	3,200.0
9	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	34,000.0	6,800.0
10	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах	500.0	500.0
11	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	37,900.0	7,960.0
Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв			65,960.0

Зангат уулын чулуун нүүрсний уурхайн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт **65,960.0** мянган төгрөг зарцуулах урьдчилсан тооцоо гарч байна.